

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/154/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.22	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
	Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор Ц.Дорж Утас: 88114307 Цахим хаяг: Dorjts@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/28
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын тайлангаар илэрсэн алдаа, зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтрээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд иргэдийн төлөөлөгчдийн хурал 7 удаа хуралдаж, Монголын Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль шинэчлэн найруулагдаж 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиар 29 төлөөлөгч сонгогдон бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

5020378

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,589,670.5</u>	<u>22,830,053.0</u>
33	АВЛАГА	633,377.5	1,403,160.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	633,377.5	1,403,160.0
35	БАРАА МАТЕРИАЛ	17,956,293.0	21,426,893.0
354	Хангамжийн материал	17,956,293.0	21,426,893.0
35410	Бичиг хэргийн материал	1,100,500.0	1,971,100.0
35420	Аж ахуйн материал	1,939,250.0	1,939,250.0
35430	Сэлбэг хэрэгсэл	2,800,000.0	5,400,000.0
35450	Барилгын засварын материал	820,010.0	820,010.0
35470	Бусад хангамжийн материал	11,296,533.0	11,296,533.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>36,204,538.4</u>	<u>43,295,636.2</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	36,204,538.4	43,295,636.2
392	Биет хөрөнгө	35,075,788.0	42,809,385.7
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,100,000.0	58,100,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-35,804,166.9	-48,804,167.0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,985,900.0	34,765,900.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15,969,733.5	-17,863,955.9
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,999,140.0	25,897,140.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,708,651.6	-9,758,831.5
39217	Ном	473,300.0	473,300.0
393	Биет бус хөрөнгө	1,128,750.4	486,250.5
39301	Програм хангамж	2,675,000.0	2,675,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,546,249.6	-2,188,749.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>54,794,208.9</u>	<u>66,125,689.2</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>397,700.0</u>	<u>00.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	397,700.0	00.0
413	Өглөг	397,700.0	00.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	388,200.0	00.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,500.0	00.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>54,396,508.9</u>	<u>66,125,689.2</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	54,396,508.9	66,125,689.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,281,230.4	21,281,230.4
51101	Өмч: - төрийн	21,281,230.4	21,281,230.4
512	Хуримтлагдсан үр дүн	31,028,252.6	42,757,432.9
51210	Өмнөх үеийн үр дүн	31,028,252.6	31,028,252.6
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	11,729,180.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,087,025.8	2,087,025.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>54,794,208.9</u>	<u>66,125,689.2</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	524,868,400.0	639,710,166.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	524,868,400.0	639,710,166.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,315,000.0	6,570,166.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,315,000.0	6,570,166.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	521,553,400.0	633,140,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	521,553,400.0	633,140,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	535,004,764.3	627,980,985.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	535,004,764.3	627,980,985.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	509,397,043.5	586,876,485.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,329,438.4	218,552,609.0
210101	Үндсэн цалин	81,896,538.4	109,185,569.7
210102	Нэмэгдэл	27,682,900.0	71,294,363.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.0	10,190,000.0
210104	Урамшуулал	12,750,000.0	27,882,676.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,210,339.5	25,357,224.4
210201	Тэтгэврийн даатгал	10,392,196.3	17,653,435.9
210202	Тэтгэмжийн даатгал	1,222,611.3	2,407,156.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,008,089.0	1,194,823.6
210204	Ажилгүйдлийн даатгал	223,494.7	750,954.7
210205	Эрүүл мэндийн даатгал	2,363,948.2	3,350,854.1
2104	Хангамж, бараа материалын зардал	20,651,090.8	14,374,702.0
210401	Бичиг хэрэг	12,050,950.0	7,475,300.0
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.0	6,113,514.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,140.8	785,888.0
2105	Нормативт зардал	10,104,700.0	00.0
210502	Хоол, хүнс	10,104,700.0	00.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,750,000.0	00.0
210604	Урсгал засвар	1,750,000.0	00.0
2107	Томилолт, зочны зардал	4,754,000.0	3,900,000.0
210702	Дотоод албан томилолт	4,754,000.0	3,900,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,220,988.0	17,082,298.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	934,500.0	17,082,298.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	286,488.0	00.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333,376,486.7	307,609,652.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	314,637,700.0	287,872,750.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.0	2,150,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,738,786.7	17,586,902.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,607,720.9	41,104,500.1

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.0	7,555,766.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.0	6,555,766.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.0	1,000,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,707,720.9	33,548,734.1
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	15,000.0	00.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,692,720.9	33,548,734.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-10,136,364.3	11,729,180.3
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-10,136,364.3	11,729,180.3

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	524,868,400.0	639,710,166.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	524,868,400.0	639,710,166.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,315,000.0	6,570,166.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,315,000.0	6,570,166.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	521,553,400.0	633,140,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	521,553,400.0	633,140,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	519,658,600.0	615,032,166.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	519,658,600.0	615,032,166.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	494,350,879.2	573,927,666.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,143,060.8	209,797,791.5
210101	Үндсэн цалин	81,710,160.8	90,657,153.2
210102	Нэмэгдэл	27,682,900.0	73,647,358.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	11,290,000.0
210104	Урамшуулал	12,750,000.0	34,203,280.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,210,339.5	26,070,024.4
210201	Тэтгэврийн даатгал	10,392,196.3	17,607,925.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,222,611.3	2,433,556.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,008,089.0	1,118,088.6
210204	Ажилгүйдлийн даатгал	223,494.7	926,378.1
210205	Эрүүл мэндийн даатгал	2,363,948.2	3,984,076.5
2104	Хангамж, бараа материалын зардал	17,888,090.8	15,245,302.0
210401	Бичиг хэрэг	9,287,950.0	8,345,900.0

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	8,000,000.0	6,113,514.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,140.8	785,888.0
2105	Нормативт зардал	9,908,700.0	-
210502	Хоол, хүнс	9,908,700.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,550,000.0	2,600,000.0
210604	Урсгал засвар	4,550,000.0	2,600,000.0
2107	Томилолт, зочны зардал	4,754,000.0	3,900,000.0
210702	Дотоод албан томилолт	4,754,000.0	3,900,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,720,988.0	17,091,798.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,431,000.0	17,091,798.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	289,988.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	315,175,700.0	299,222,750.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	315,175,700.0	297,072,750.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,150,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,307,720.9	41,104,500.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.0	7,555,766.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	6,555,766.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.0	1,000,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,707,720.9	33,548,734.1
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	15,000.0	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,692,720.9	33,548,734.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,209,800.0	24,678,000.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,209,800.0	24,678,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,209,800.0	24,678,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	5,209,800.0	24,678,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,209,800.0	24,678,000.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,209,800.0)	(24,678,000.0)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.4	2,087,025.8	31,028,252.6	54,396,508.9

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,281,230.4	2,087,025.8	31,028,252.6	54,396,508.9
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.4	2,087,025.8	31,028,252.6	54,396,508.9
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.4	2,087,025.8	31,028,252.6	54,396,508.9
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,281,230.4	2,087,025.8	31,028,252.6	54,396,508.9
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	11,729,180.3	11,729,180.3
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.4	2,087,025.8	42,757,432.9	66,125,689.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	633,140,000.0	599,591,266.0	33,548,734.1	94.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,140,000.0	599,591,266.0	33,548,734.1	94.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	632,140,000.0	598,591,266.0	33,548,734.1	94.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,987,800.0	209,797,791.5	9,190,008.5	95.8
210101	Үндсэн цалин	95,592,700.0	90,657,153.2	4,935,546.8	94.8
210102	Нэмэгдэл	84,455,100.0	73,647,358.3	10,807,741.7	87.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,200,000.0	11,290,000.0	1,910,000.0	85.5
210104	Урамшуулал	25,740,000.0	34,203,280.0	-8,463,280.0	132.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,956,200.0	26,070,024.4	886,175.6	96.7
210201	Тэтгэврийн даатгал	17,889,800.0	17,607,925.0	281,875.0	98.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,163,500.0	2,433,556.2	-270,056.2	112.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,081,700.0	1,118,088.6	-36,388.6	103.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,081,700.0	926,378.1	155,321.9	85.6
210205	Эрүүл мэндийн даатгал	4,739,500.0	3,984,076.5	755,423.5	84.1
2104	Хангамж, бараа материалын зардал	15,416,000.0	15,230,902.0	185,098.0	98.8
210401	Бичиг хэрэг	8,346,000.0	8,345,900.0	100.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	6,120,000.0	6,113,514.0	6,486.0	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	950,000.0	771,488.0	178,512.0	81.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,280,000.0	27,278,000.0	5,002,000.0	84.5

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	20,750,000.0	15,780,000.0	4,970,000.0	76.0
210602	Тавилга	8,900,000.0	8,898,000.0	2,000.0	100
210604	Урсгал засвар	2,630,000.0	2,600,000.0	30,000.0	98.9
2107	Томилолт, зочны зардал	4,260,000.0	3,900,000.0	360,000.0	91.5
210702	Дотоод албан томилолт	4,260,000.0	3,900,000.0	360,000.0	91.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,957,000.0	17,091,798.0	865,202.0	95.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,306,000.0	17,091,798.0	214,202.0	98.8
210803	Даатгалын үйлчилгээ	318,000.0	00.0	318,000.0	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.0	00.0	300,000.0	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	00.0	33,000.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	316,283,000.0	299,222,750.0	17,060,250.0	94.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	313,283,000.0	297,072,750.0	16,210,250.0	94.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.0	2,150,000.0	850,000.0	71.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.0	1,000,000.0	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.0	1,000,000.0	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	1,000,000.0	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	633,140,000.0	633,140,000.0	-	100
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	633,140,000.0	633,140,000.0	-	100
132001	Орон нутгийн төсвөөс	633,140,000.0	633,140,000.0	-	100
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6	-	100
620001	Удирдах ажилтан	2	2	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,315,000.0	6,555,766.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,315,000.0	6,555,766.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,315,000.0	6,555,766.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,315,000.0	6,555,766.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,315,000.0	6,555,766.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,315,000.0	6,570,166.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,315,000.0	6,570,166.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,315,000.0	6,570,166.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь “Ардчилсан нийгэм дэр зах зээлийн эдийн засгийн харилцааны орон нутгийн удирдлагын үйл ажиллагааг нийцүүлэн орон нутгийн бие даасан хөгжлийг хангах, Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогыг зүй зохистой тодорхойлон түүнийг хэрэгжүүлэхэд сумын иргэдийн бүтээлч санаачлаг идэвхтэй оролцоог нимгэдүүлэх, сумын засаг дарга, түүний тамгын газар, төр орон нутгийн өмчид байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлэн чанаржуулж төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, тэдний язгуур, эрх ашгийг дээдлэн аж байдлыг хэлбэрэлтгүй нимгэдүүлэн нутгийн өөрийн удирдлагын чадавхыг дээшлүүлэх гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант онд сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааныг 7 удаа хуралдуулж цаг үеийн асуудлуудыг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)

• Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсээс 2021 онд гаргасан "Төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,331.5 мянган төгрөг буюу 20.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		/мянган төгрөгөөр/	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,589.7	33.9	22,830.1	34.5	4,240.4	37.4
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-	-	-	-

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

АВЛАГА	633.4	3.4	1,403.2	6.1	769.8	18.2
УРЬДЧИЛГАА			-		-	
БАРАА МАТЕРИАЛ	17,956.3	96.6	21,426.9	93.9	3470.6	81.8
НӨӨЦИЙН БАРАА	-		-		-	
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	36,204.5	66.1	43,295.6	65.5	7,091.1	62.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	36,204.5	66.1	43,295.6	65.5	7,091.1	62.6
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(61,028.7)	(111.3)	(78,615.6)	(118.9)	(17,586.9)	(155.2)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	54,794.2	100	66,125.7	100	11,331.5	100
НИЙТ ӨР ТӨЛБӨР	397.7	0.7	-	-	(397.7)	(3.5)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	54,396.5	99.3	66,125.7	100	11,729.2	103.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	54,794.2	100	66,125.7	100	11,331.5	100

Авлага дансны үлдэгдэл 1,403.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 769.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 21,426.9 мянган төгрөг болж өмнөх оноос 3,470.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар Бичиг хэргийн материалд 13,806.4 мянган төгрөг, Сэлбэг хэрэгсэлд 2,600.0 мянган төгрөг, Түлш, шатах тослох материалд 6,113.5 мянган төгрөг, Хүнсний материалд 15,902.0 мянган төгрөг, бусад хангамжийн материалд 25.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч. Бичиг хэргийн материал, Түлш, шатах тослох материал, хүнсний материал, бусад хангамжийн материалыг зарцуулсан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 43,295.6 мянган төгрөг болж 7,091.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 3 нэр төрлийн 3 ширхэг 15,780.0 мянган төгрөгийн хурлын хуралдааны үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж, 12 нэр төрлийн 34 ширхэг 8,898.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг орлогод авсан байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 66,125.7 мянган төгрөг, тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 11,729.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Өр төлбөр нь өмнөх оноос 397.7 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 410,286.5 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 173,173.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 633,140.0 мянган төгрөгөөр баталсан байна. 2024 оны 9 дүгээр сарын 25 -ны өдрийн сумын иргэдийн төлөөлөгчдийн ээлжит 16 дугаар хурлаар албан

хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох үүднээс 49,140.0 мянган төгрөгийн санхүүжилт өссөн холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн санхүүжилтээр 633,140.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 599,591.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 599,591.2 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь үндсэн болон нэмэгдэл цалин, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 31,906.3 мянган төгрөг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	563,100.0	530,767.8	32,332.2	94.2
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,000.0	1,000.0	-	100
3	80825 Багийн ИНХ-ийн даргын урамшуулал	29,040.0	27,870.5	1,169.5	96
4	82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	40,000.0	39,952.9	47.1	99,9
5	Дүн	633,140.0	599,591.2	33,548.8	97.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс 5 жил ажилласан төрийн алба хаагчийн нэг удаагийн 6,555.7 мянган төгрөгийн тэтгэмж орж ирсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 3 нэр төрлийн 3 ширхэг 15,780.0 мянган төгрөгийн хурлын хуралдааны үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж, 12 нэр төрлийн 34 ширхэг 8,898.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг орлогод авсан байна. Оны эхэнд Шунхлай трейдинг ХХК -тай тээвэр шатахууны зардал дээр 6,100.0 мянган төгрөгийн шууд гэрээ хийсэн. Тус байгууллага нь Баянхонгор сумын Засаг даргын тамгын

газрын байранд үйл ажиллагаа явуулдаг тул байр ашиглалттай холбоотой тогтмол зардал гардаггүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 16/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Ж.Бямбасүрэн, түр олон гүйцэтгэгчээр мэргэжилтэн Д.Цэрэндолгор нар, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Лхамжав, нягтлан бодогч Д.Эрдэмээ нар зурсан байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 633,140.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,331.4 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 4,115.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5.4 заасны дагуу хамаарах асуудал байхгүй бөгөөд үндсэн болон нэмэгдэл цалин, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 31,906.3 мянган төгрөг зарцуулаагүй хэмнэлт гарч улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитын асуудалд алдаа зөрчил илрээгүй.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаас мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан орлогын 651,695.8 мянган төгрөгийн 33 гүйлгээг хугацаанд нь 30,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 15,100.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг хуулийн хугацаанд нь 14,200.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан орлогын 30,000.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл, зарлагын 14,200.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг мэдээлэх албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймгийн Номгон аудит ХХК -ийн захирал Г.Саранчимэг гүйцэтгэж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар хяналтыг хэрэгжүүлсэн байна. Алдаа зөрчил илрээгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64,849.7 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 64,849.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгсөн болно.

5.1 Албан шаардлага

5.1.1 2024 оны 6 дүгээр сард нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн дүнгээс дутуу мэдээлсэн 484.0 мянган төгрөг, 7 сард багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарын урамшуулал 6,600.0 мянган төгрөгийг мэдээлээгүйгээс болж нийгмийн даатгалын байгууллагаас авлагатай гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулах”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25 -ны өдрийн А/199 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам” -ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ дутуу мэдээлсэн 7,084.0 мянган төгрөгийн цалинг нөхөж мэдээлэх албан шаардлага өгч байна.

5.1.2 Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан орлогын 651,695.8 мянган төгрөгийн 33 гүйлгээг хугацаанд нь 36,555.7 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 15,100.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг хуулийн хугацаанд нь 14,200.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан орлогын 36,555.7 мянган төгрөгийн 2 мэдээлэл, зарлагын 14,200.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг мэдээлэх албан шаардлага өгч байна.

5.1.3 Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 08 дугаар сарын 01 -ны өдрийн 21 дугаар захирамжаар Баянхонгор сумын 2020-2024 онд сонгогдсон төлөөлөгч нарын “Хүндэтгэлийн хуралдаан” -ыг 2024 оны 08 дугаар сарын 09 -ний өдөр хуралдаан зохион байгуулж төлөөлөгч нарт гарын бэлэг 7,010.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 -т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн “15.2.7. сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийн хөрөнгөөр хурал зөвлөгөөн, бэлэг дурсгалын зүйл худалдан авахгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгч байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөж мэдээлэх. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам" 2024 оны 7 дугаар сард багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нарын урамшууллыг НДШ мэдээлээгүй байна.	1	7,084.0			1	7,084.0		
Дүн	1	1,416.0	1	1,416.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-д заасан орлогын 36,555.7 мянган төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 14,200.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	50,755.7			1	50,755.7		
Төрийн хэмнэлтийн тухай хууль								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 -т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн "15.2.7. сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх." гэсэн заалтыг зөрчиж төлөөлөгч нар хүндэтгэл үзүүлсэн байна.	1	7,010.0			1	7,010.0		
Дүн	2	57,765.7			2	57,765.7		

-----oOo-----